

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЭНГЭТМЭЭР УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

# ТҮҮХ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



INDIA

# Гарчиг

## Эрхэм уншигч Танаа

5

### Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

### Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

### Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

### Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

### Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

### Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

### Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

**Франц улсын Парис хотын монгол сурагчид  
Лүүхэн тэмдэглэл/**

**Р.Төрдалай**

1920-иод оны дундуур Монголоос өрнөдөд окутан, сурагч илгээж байсны нэг хэсэг нь Францад очжээ. Аюурзана, Дүгэрсүрэн, Намсрай, Уртнасан зэрэг дөрвөн сурагч Францын нийслэл Парис хотод Lycee Michelet гэдэг эдийн засгийн сургуульд суралцаж байжээ. Эдгээр сурагчид Парис хотод хэзээ хүрэлцэн очсон тухай мэдээ баримт ховор байгаа боловч мэргэн хэмээх Гомбожаваас дарга Ишдоржид бичсэн захидалдаа:

"... Бидний биес замын зуур сайн явсаар Парис хотноо ирээд Пеллио нарын зэрэг хүмүүс лугаа уулзан танилцаж, аливаа хэрэг зоригоо бүтээсээр бүхийгээс гадна энд Парис хотод тусгайлан гадаадын хүмүүсийг "Фа" улсын хэл бичигт боловсруулах оруулахад оруулав. Ирсээр нэг өчүүхэн дэнд буусан нь эдүгээ хүртэл суусаар даруй ... айлд суух санаатай. Энд бүхий манай Монголын дөрвөн хүүхэд цөм мэнд сайн бөгөөд уг сургууль дороо суралцаар байна. Гомбожав. 1927.2.24. 1 Bis rue Yacuyrede, Hotel du Jardin, Paris"<sup>1</sup> гэжээ.

Дээрхи дөрвөн сурагч Герман улсын Фронау /Frohnau/ дахь Монгол улсын багш, сурагчдын байрлаж байсан газар сууж байгаад улмаар 1927 оны эхээр Францын Парис хотноо суралцахаар явсан бололтой байна. Парис хот дахь монгол сурагчдын хичээл сургууль ба ахуй амьдралтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг "Герман, Франц улс дахь монгол сурагчдын захиргаа"-ны дарга Б. Ишдоржийн туслах байсан мэргэн Гомбожав хариуцан ажиллаж байжээ.

Мэргэн Гомбожав нь Франц улсад суралцахаасаа өмнө 1925-1926 онд ЗХУ-ын Дорно дахины сургуульд суралцаж байсан байна. Гомбожав дээрхи хариуцлагатай ажлыг хариуцан гүйцэтгэж байсны зэрэгцээ Францын нэртэй эрдэмтэн П. Пеллиог дагалдан эрдэм, шинжилгээ судалгааны ажил хийж байжээ. Учир нь мэргэн Гомбожав, мөн Ж. Цэвээний эхнэр Бадамжав нар нь Судар бичгийн хүрээлэнгийн томилолтоор тус улсад суралцаж байв. Бадамжав нь Париж хотод байхдаа хэл шинжлэлийн ухааныг судалж, франц хэл үзэж байжээ. Хэдийгээр Серж Вольфийн өгүүлэлд Франц улсад суралцаж байсан монгол сурагчдын тухай дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байгаа ч мэргэн Гомбожав, Бадамжав нарын тухай тодорхой өгүүлсэн байдаг. Тэрээр бичихдээ: "... Тэр хоёр хоёулаа ихээхэн ухаантай, сонирхолтой сайхан хүмүүс байв. .... Гомбожав биеэ авч явах байдал, оюун ухаан, ялдам сайхан зангаараа асар их сэтгэгдэл төрүүлж билээ"<sup>2</sup> гэжээ.

Парис хотын сурагчдын бичсэн захидал мэдээнээс тэдний Францын эхний үеийн байдлыг тодруулах боломжтой юм. 1927 оны III сарын 7-нд "Герман, Франц улс дахь монгол сурагчдын захиргаа"-нд бичсэн захидалдаа Парис хотын сурагчид бичихдээ:

"... Анхнаа энэхүү улсад ирснээр хоёр сар нэг орос багшаар франц хэл, бичгийг өдрийн гурван цаг хиртэйгээр заалгаж байсан. Үүний тэргүүн сард нөгөө олгосон багш сайн зааж байгаад дараах нэг сард уг ноогдсон цагтаа ирж заахгүйгээр хожимдож оройтох зэргээр мөн сарыг өнгөрүүлэв. Дараа эл сургуульд хүрч ирээд дөрөвдүгээр болон зургадугаар ангиудаар хоёр, хоёроор орж тус сургуулийн аливаа заасан зүйлүүдийг гүйцэтгэх үүрэгтэй болсон нь мэдэж чадахгүй зүйл нэн үлэмж болох"<sup>3</sup> гэснээс үзвэл Lycee Michelet-ийн сургууль дахь Монгол сурагчид эхний үед хэлний бэлтгэл хийж байгаад дараа нь тус сургуульд элсэн суралцсан нь тодорхой байна. Тэдний эрхлэгч, багш нартаа

бичсэн тайлан захидлыг авч үзвэл Франц дахь Монгол улсын дөрвөн сурагчдад эхний үед хэлний бэрхшээлээс шалтгаалан зохих хүндрэл бэрхшээл их гарч байжээ. Сурагчид өглөөний найман цагаас оройн дөрвөн цаг хүртэл хичээллэж дөрөвдүгээр ангид суралцаж байсан франц, англи, герман хэл судалж байсан бол зургадугаар ангийн сурагчид франц, англи хэл үзэхийн зэрэгцээ түүх, физик, дэлхийн байдал, тооны ухаан, биеийн тамир гэх мэт хичээлүүдийг судалж байв.

Мөн эдгээр сурагчидтай холбоотой баримтуудыг нягтлан үзэхэд тэдний суралцаж байсан уг сургуулийн захиргаанаас сурагчдын хичээл болон сахилга хүмүүжилд ихээхэн анхаарал тавьж байсан нь харагддаг. Энэ үүднээс монгол сурагчдад гадаадынхны хамт тусгай хөтөлбөрөөр цагт 10 франкын хөлстэйгээр долоо хоногт хоёр удаа нэг цагийн хугацаатайгаар франц, хэл бичгийг заах болсон байна. Гэвч уг хичээл нь төдий л үр дүнтэй болж чадахгүй байжээ. Учир нь Герман улс дахь монгол сурагчид хичээл сургуульдаа илүү чөлөөтэй суралцаж, Герман сурагчидтай ойр дотно нөхөрлөж байсан бол Франц дахь монгол сурагчдын хувьд тухайн улсын хэл, бичгийг сурах нөхцөл бололцоо Герман улс дахь монгол сурагчидтай харьцуулахад хангалттай биш байжээ.

Энэ тухай сурагчид дээрхи захидалдаа: "...Уул цаг цагийн хичээлийг заагч багш нар нь ярилцах хэл ба бичиг мэдэхгүй болохуйд тусгайлан үзэж сургахыг эрмэлздэггүй бөгөөд зөвхөн ноогдол цагаа өнгөрүүлэх төлөвтэйл.

... Мөн гадаалж унтах цагаас бус, унтах ба энгийн хичээл үйлдэх явдалд тусгай багш нар харан захиран байдаг, эдгээр сургагч нар нь тун ч бэрх хэцүү. Хөвгүүд нарыг хооронд нь нэг ч дуу гарган яриулахгүй байна, энэ болбоос бидэнд их л харштай явдал болно. Учир нь ...бусдаас бага сагыг заалгаж сонсохыг хүсэвч энэ байдалд орох нь төвөгтэй. Мөн ганц хоёр үгийг бусдаас асуугаад мэдэхийн завсар хэрэв мэдэгдвээс сонсвор хүртэх болдог. Өөрсдөө мэдвээс баярлан эс мэдвээс хохироод өнгөрдөг<sup>4</sup> гэсэн нь дээрхи байдлыг баталж байна.

Тус хот дахь Монгол сурагчид Герман Берлин хот дахь "Герман, Франц улс дахь Монгол Сурагчдын захиргаа"-тай байнга холбоотой байж"... өр бид нарт гачигдсан зүйл нилээд олон. Тус сургуулиас аливаа хэрэглэгдэхүүнийг бэлтгэн өгч байхаар хэлэлцэв гэж урьдын дарга нар нь одсон бүлгээ. Эдүгээ энэ ёсоор элдэв хэрэглэсэн зүйлүүдийг үл бэлтгэж өгмүй<sup>5</sup> гэх зэргээр хүсэлт гаргаж хэрхэн сурч амьдарч байгаагаа тайлагнан бичиж байжээ.

Франц улс дахь монгол сурагчид 1927 оны VI сарын 30-нд бичсэн захидалдаа дурьдсанчилан 1927 оны хичээлийн амралтаар Франц улсын баруун хойд этгээд дэх хөдөө нутагт очиж франц хэл, бичиг суралцахаар төлөвлөж байсан бөгөөд сургуулийн захиргаанаас тэдэнд хэл, бичиг заах тусгай багшийг томилж өгсөн байна. Архивийн болон бусад холбогдох баримтуудаас үзвэл 1927 оны VII сарын 12-ны өдөр Монгол сурагчид дээрхи газраа хүрэлцэн ирсэн бөгөөд энэ газар Парис хотын баруун хойд зүг, Британи улсын хойд булангийн ойролцоо Атлантын далайн эрэг дээр орших нэгэн айлын байшинд /plougrescant / суух болжээ. Сурагчид энэхүү сууж байсан газраа тодорхойлон бичихдээ: "мөнхүү энэ газар суухуйд төдий л дутагдсан зүйлгүй бүгд мэнд суухын инард ... заадаг багшийн зан ааш нь сайн бөгөөд заримдаа багшийн хамтаар хөдөө тал, далайн эргээр явж юм үздэг. Мөн ч хөдөө газар суухуйд биесүүдэд нэн тааламжтай амой"<sup>6</sup>

Мөн сарын 20-нд бичсэн бас нэг захидалдаа: "... Энэ газрын хүмүүс цөмөөрөө Британи хэлээр ярилцдаг. Францаар хэлэлцэх хүн цөөхөн, бидний байгаа айл франц хэлээр хэлэлцмөй"<sup>7</sup> гэж бичсэн зэргээс үзвэл Монгол сурагчид энэхүү хөдөө газар амарч байх хугацаандаа франц хэл бичигт суралцах өргөн боломж олдсон байна. Ялангуяа сурагч Уртнасан бусад нөхдөөсөө илүү

амжилттай суралцаж, тухайн улсын хэл, бичгийг сайн сурч байсан нь түүний 1927 оны VII сарын 20-нд Ишдорж даргад бичсэн захидлаас тодорхой байна. Тухайн үед Франц улсын нийслэл Парис хотод суралцаж байсан дөрвөн сурагчдаас илгээсэн нэгэн захидлыг 1927 оны X сарын 29-ний өдрийн "Үнэн" сонины №85-д "Францын нийслэл Парис хотноо буй сурагч нарын байдал" гэсэн нэртэйгээр нийтлэгдсэн байна.<sup>8</sup>

Сурагчид энэхүү захидалдаа зуны амралтаа хэрхэн өнгөрүүлсэн тухайгаа бичсэн байдаг. Монгол сурагчид зуны амралтаараа хичээл болон франц хэл бичгийг шамдан үзэхээс гадна тэдний бичсэнээр: "... завсарт тэндэхийн ойр орчмын их, бага хот балгад, эрт урьд цагт байгуулсан элдэв гайхамшигтай хуучин сүм байшин, хөшөө чулуу хийгээд хөдөөний айл, тосгоны аж үйлдвэр, ард нийтийн байдлыг их л сонирхон<sup>9</sup> Франц оронтой танилцан удирдагч багшийн хамтаар аялалд явж байсан баримт байна. Монгол сурагчид энэхүү Атлантын далайн эрэг дэх хөдөө нутагт 1927 оны IX сарын 20-н хүртэл суралцаж байхдаа олон сонирхолтой зүйлийг танин мэдэж суралцсан байна.

Ийнхүү зуныхаа амралтыг үр дүнтэй өнгөрүүлж, франц хэл бичигт шамдан суралцсаны үр дүнд 1927/1928 оны хичээлийн жилд цөм анги дэвшин суралцаж чадсан нь тэдний 1927 оны X сарын 3-нд захидал бичсэнээс тодорхой байна.

Парис хотын Монгол сурагчид сурах зорилго, эрмэлзлэлээ тодорхойлон: "... бидний санал хэдий их авч хэрэв харьяат дарга эрхлэгч нарын энэ жил тушаасныг эцэс жилийг нөхцөл дагаж хариу чимээгүй суух үүрэг ийм болсон учир, сурч гэгээрэхүйд зориг мөхөсдөхгүйгээр хичээж дутагдал, гачигдал байсан боловч мухардахгүй.

... зэрлэг байдал, бүдүүлэг суртлаас бидний Монгол нийгэмдээ ангижрах гүн зорилго, хүүрнэн хөгжиж шинэ цагийн боловсролд эрдмийн ирээр ийм гайхамшиг боловсролын туйлыг дэлгэрүүлэн, гадаадын нэгэн их улсад хүрэлцэн ирсэн нь их үүрэг<sup>9</sup> гэж бичсэн нь тэд улс орондоо шинэ үеийн соёл, боловсролыг дэлгэрүүлэн хөгжүүлэх үндсэн дээр хөгжин дэвших үйл хэрэгт тус дөхөм болохыг зорьж байсан ажээ. Франц улсын Парис хотын Монгол улсын дөрвөн сурагч 1930 оныг хүртэл тус улсад суралцаж байх хугацаандаа Герман улсад суралцаж байсан Монгол оюутан, сурагчидтай байнга харилцаатай байсан бөгөөд энэ тухайгаа тэд: "... Берлин хотноо байгаа сургуулийн олон нөхөдтэй үргэлж захидал бичиг харилцан авалцдаг"<sup>10</sup> гэж өгүүлсэн байдаг.

Парисын Монгол сурагчид дээр дурьдсанчилан Lycee Michelet-ийн сургуульд идэвхтэй суралцаж байжээ. Харин дээрхи дөрвөн сурагчдын бүхий л асуудлыг хариуцан ажиллаж байсан мэргэн Гомбожав нь Парис хотод П.Пеллиотой хамтран ажиллаж байх хугацаандаа франц хэл, бичгийг сайтар сурч, Ардыг Гэгээрүүлэх яамнаас үүрэг даалгаварыг эндэгдэлгүй гүйцэтгэж байсан тул түүнийг "Герман, Франц улс дахь Монгол сурагчдын захиргаа"-ны даргаар томилохоор бэлтгэж байжээ.

Хэдийгээр тухайн үед Монгол улсын соёл, боловсролын гадаад харилцааны үйл ажиллагаа нь баруун Европын орнуудаас Герман улстай голлон тогтож байсан боловч Франц улс нь Германы дараагаар манай улстай найрсагаар харилцаж байсан гуравдагч орон болсон байна.

Энд уг асуудлаар дэлгэрэнгүй судалгаа хийх зорилго тавиагүй бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай сэдэв юм.

**Ишлэл, зүүлт**

1. УТА, Ф-6, Д-1, ХН-140, ХД: 6
2. Serge M. Bo Wolff. "Mongol delegation in Western Europe /1926-1929/" "Royal Cunval Asian Journal". London and Cavevsham /Berks/, 1944.
3. УТА, Ф-6, Д-1, ХН-140, ХД: 10-11
4. Мөн тэнд.
5. Мөн тэнд, ХД: 13
6. Мөн тэнд, ХД: 37
7. УТА, Хэвлэлийн Фонд, ХН-2, "Үнэн" сонин, 1927.10.29,
8. Мөн тэнд
9. УТА, Ф-6, Д-1, ХН-140, х:57
10. Мөн тэнд, ХД: 47.